

ТАНИЛЦУУЛГА

1. Үндэслэл

- Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 16 дугаар зүйлийн 16.1.15-д заасан эрх зүйн үндэслэлээр шинэчлэн боловсруулав.
- 2020 онд батлагдсан хуучин журам нь цаг үеийн шаардлага, тухайлбал цахим жор бичих тогтолцоо, биометрик баталгаажуулалт, эрүүл мэндийн даатгалын цахим системтэй бүрэн уялдаагүй байсан.
- Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд оролцогч талуудын (даатгуулагч, эмч, эмийн сан, ЭМДБайгууллага) эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эрх зүйн орчныг өнөөгийн бодит нөхцөлд тохируулах шаардлагатай болсон.

2. Шинэчлэх ач холбогдол

- Эмийн цахим жор бичих, олгох хэсэг: Эмчилгээний тун, хугацааг олон улсын эмнэлзүйн удирдамжтай уялдуулж, хэтрүүлэн бичихээс сэргийлнэ.
- Хариуцлагын тогтолцоо: Зөрчил гаргасан эмийн сан, эмчид ногдуулах хариуцлагыг (санхүүжилт түдгэлзүүлэх, гэрээ цуцлах) нарийвчлан тодорхойлсон.

3. Шинээр боловсруулсан журмын үндсэн агуулга

• Нийтлэг үндэслэл:

Журмын зорилго, хамрах хүрээ, эмийн зохистой хэрэглээ, сангийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг тодорхойлно.

• Оролцогч талуудын эрх, үүрэг:

Даатгуулагч, эрүүл мэндийн даатгалын байгууллага, жор бичих эрх бүхий эмч/байгууллага, эмийн сан гэсэн дөрвөн субъектийн эрх, үүргийг тус тусад нь дэлгэрэнгүй заасан. Үүнд цахим жор, хурууны хээний баталгаажуулалт, 15 минутын доод үзлэгийн хугацаа, 14 хоног тутмын цахим нэхэмжлэлээр санхүүжүүлэх журам зэрэг орно.

• Хориглох зүйл:

Эмийн сан, эмч, даатгуулагч тус бүрт хориглох үйлдлийг (үнэ хэтрүүлэх, жор хуурамчаар бичих, эрх шилжүүлэх зэрэг) тодорхой жагсаав.

• Хариуцлага:

Зөрчлийн төрлөөс хамаарсан шат дараалсан хариуцлага (санхүүжилт түдгэлзүүлэх, гэрээ цуцлах, хохирол нөхөн төлүүлэх, тусгай зөвшөөрлийн байгууллагад мэдэгдэх) тусгасан.

4. Хүлээж буй үр дүн

- Даатгуулагчид эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, цахим хэлбэрээр үзүүлэх боломж бүрдэнэ.
- Цахим хяналтын нэгдсэн тогтолцоо бий болж, хуурамч жор, зохисгүй эмийн хэрэглээ, сангийн урсгал алдагдал буурна.
- Оролцогч бүх талын эрх, үүрэг, хариуцлага тодорхой болсноор маргаан, гомдлыг цахимаар шуурхай шийдвэрлэх боломжтой болно.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг зорилтот, үр ашигтай байдлаар зарцуулж, урт хугацаанд тогтвортой байдлыг хангана.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР